



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 13 өдөр

Дугаар М226

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46,1, 47 дугаар зүйлийн 47,1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвийн хатуу хучилтай замын өргөтгөл, шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Мөнхбат -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн  
Нарийн бичгийн дарга: Ц.Оюун -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн  
Гишүүд: Б.Баяржаргал -аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч  
З.Нацагням -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн  
Ш.Авирмэд -Бүтээлч хөгжлийн хөтөч ТББайгууллагын гишүүн (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж нийлүүлэгчийг сонгон шалгаруулж мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг үнэлгээний хороо (Б.Мөнхбат)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивийн нэгж бүрдүүлж, архив бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ц.Оюун)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100493